



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/117 -

Бат-Өлзий сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Үнэлгээний хорооны 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 02 дугаар зөвлөмжийг үндэслэн Сумын төвийн наймаа булан рамын дэнжид үерийн далан байгуулах ажлын төхдөрийг 162,167,506 (нэг зуун жаран хоёр сая нэг зуун жаран долоон мянга таван зуун зургаан) төгрөгөөр “Тулгат зам” хязгаарлагдмал хариуцлагатай компаниар гүйцэтгүүлсүгэй.

2. Тендерт шалгарсан “Тулгат зам” хязгаарлагдмал хариуцлагатай компанитай гэрээ байгуулж, ажлын явцад хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

3. Зардалд шаардагдах 162,167,506 (нэг зуун жаран хоёр сая нэг зуун жаран долоон мянга таван зуун зургаан) төгрөгийг гэрээний дагуу, Орон нутгийн хөгжлийн сангийн бусад хөрөнгө данснаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

4. Шалгарсан аж ахуйн нэгж санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн авч гэрээний дагуу санхүүжилт өгөхийг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН